



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 14 өдөр


Дугаар А/310

Номгон

Төрийн архивын дэргэдэх Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төв байгуулах тухай

Төрийн нийт албан хаагчдын Архив, албан хэрэг хөтлөлтийн мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 м, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний 115 дугаар тогтоолоор баталсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн 5.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Төрийн архивын дэргэд Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төв байгуулсугай
- 2.Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төвийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг хавсралтаар баталсугай.
- 3.Сургалтын төвийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн архив (В.Эрдэнэчимэг), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т тус тус үүрэг болгосугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал) -т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010795